



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2016.05.01 № ХЭГ/1444
танай _____-ны № 17 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Ч.Анар нараас ирүүлсэн "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль"-ийн хэрэгжилтийн талаарх асуулгын хариуг бэлтгэн Танд үүгээр хүргүүлж байна.


Хавсралт 05 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265006023



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2024 оны 06 дугаар сарын 05-ны
өдрийн Хэргийн 1944 дугаартай албан
бичгийн хавсралт.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ЗОЛЖАРГАЛ, Ч.АНАР НАРААС
ИРҮҮЛСЭН АСУУЛГЫН ХАРИУ

Монгол Улсын Их Хурлаар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр хэлэлцэн баталсан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасны дагуу Засгийн газрын 2025 оны 98 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс”-ийг байгуулахаар шийдвэрлэж, тус хуулийн 11.7, 13.2, 13.3 дахь хэсэгт заасан “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг тус тус баталсан. Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулж, 2026 оны 01 дүгээр сараас e-business системээр дамжуулан хуулийн этгээдийг уг виртуал бүсэд бүртгэж эхлээд байна.

Асуулга 1. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т “мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө” гэж заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэгийн эх үүсвэрийг 2024-2026 онд бүрдүүлээгүй шалтгаан, нөхцлийн талаар:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ.” гэж, 23.3 дахь хэсэгт “Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.” гэж, 23.4 дэх хэсэгт “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.” гэж тус тус заасан.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тодорхойлох бүрэн эрхийг Засгийн газар хэрэгжүүлэхээр заасны дагуу тогтоолыг төслийг боловсруулаад байна.

Цаашид “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу жил бүрийн төсвийн цаглабын хүрээнд Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн татварын болон татварын бус дэмжлэгийн төрөл, хэмжээ, эх үүсвэрийн мэдээллийг багтаасан

төлөвлөгөөний төсөл, зардлын тооцооллыг салбарын яам бэлтгэж, тухайн зориулалтаар зардлыг хянан үзэж, төлөвлөх боломжийг бүрдүүлээд байна.

Асуулга 2. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т “виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох;” гэж заасан виртуал бүсэд бүртгэлтэй этгээдийн нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговрыг олгох ажиллагаа хэрэгжихгүй байгаа шалтгаан, нөхөн олгож эхлэх хугацаа:

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т заасан татварын бус дэмжлэг нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгохоор заасан боловч Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжид “нөхөн олговор” олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй байгаа нь хэрэгжилтийг удаашруулж байна.

Асуулга 3: Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.18, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь” гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Шинжлэх ухаан, технологийн сангуудын хөрөнгийн 5-аас доошгүй хувийг мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулахгүй байгаа шалтгаан:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдаж, энэ хуульд заасан журмын дагуу хяналт тавьж тайлагнана” гэж заасан. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтын талаар нарийвчлан тодорхойлж, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулахаар тусгасан.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт нь дээр дурдсан хуулийн зохицуулалттай зөрчилтэй байгаа юм. Мөн тусгай сангийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй буюу үүрэг хүлээлгүй зөвхөн зарцуулах эрх олгосон байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т “Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь”-ийг жил бүр мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулахаар хуульчилсан хэдий ч уг хөрөнгийн зарцуулалтын эрх тухайн санд байх эсэх, эсхүл цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хөрөнгийг шилжүүлэн захиран зарцуулах эрх олгох эсэх, тухайн сангийн үндсэн зориулалтын хүрээнд дэмжлэг гарах эсэх, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд уг хөрөнгийг шилжүүлэн буюу төсөвт зохицуулалт хийж зарцуулах эрхийг нээх эсэх нь тодорхойгүй байна.

Тусгай сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нар болох Эдийн засаг, хөгжлийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарт сангийн хөрөнгөөр тухай жилд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлахад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих, энэ чиглэлээр үйл ажиллагаа, үйлчилгээ явуулж байгаа хуулийн этгээдийг өөрийн сангийн эрхлэх асуудлын хүрээнд уялдуулан дэмжих асуудлыг төлөвлөхтэй холбоотой Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулахыг үүрэг болгосон. Уг тогтоолын төслийн хүрээнд эдгээр байгууллагатай хамтран ажиллаж нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль тогтоомжийн саналыг мөн боловсруулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар зохицуулж байгаа харилцаа нь хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээнд эдийн засгийн бүхий л салбарт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж дэмжихэд чиглэдэг. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд жил бүр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-г шинэчлэн баталж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлж хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх үйл ажиллагаанд 2025 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 594.0 сая төгрөг зарцуулсан бол 2026 онд 1.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн;
- Цахим ур чадварын сургалтын арга хэмжээнд 2025 онд 138.1 сая төгрөг зарцуулсан бол 2026 онд 258.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн;
- Гарааны бизнес эрхлэгч болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2025 онд мэдээллийн технологийн салбарын 7 баг шалгарч, 112.0 сая төгрөгийн дэмжлэг авсан;
- Мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны хүрээнд 2025 онд мэдээллийн технологийн салбарын мэргэжлээр 61 иргэн сургалтад хамрагдсан;
- Ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд 2025 онд 132 иргэн мэдээлэл технологийн салбарын ажил мэргэжлээр ажлын байранд зуучлагдсан байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.18, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь” гэж заасан бөгөөд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд 2020 оноос хойш улсын төсвийн санхүүжилт тусгагдаагүй тул дээрх зориулалтаар зээл олгогдоогүй байна. Харин зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 2020-2025 онд нийт 1307 аж ахуйн нэгжид 168.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон нь нийт ирүүлсэн хүсэлтийн 14 хувийг эзэлж байна.

Асуулга 4: Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх” гэж заасан бодит байдалд хэрэгжихгүй байгаа шалтгаан, Засгийн газар ямар арга хэмжээ авах талаар:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төрийн цахим үйл ажиллагаа, нийтийн мэдээллийн дэд бүтцийг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах, нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргахаар заасны дагуу төрийн байгууллагууд мэдээллийн

системийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын хуулийн этгээдийн хийж гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээг худалдах авах, хувийн хэвшлийг дэмжих, программ хангамж үйлдвэрлэгчидтэй өрсөлдөхгүй байх шийдлийг гарган Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор “Үндэсний программ хангамжийн цахим их дэлгүүр (www.mindgolia.mn)”-ийг нийтийн мэдээллийн дэд бүтцийн дэмжих системийн хүрээнд ашиглалтад оруулсан.

Уг системийг ашиглан мэдээллийн технологийн үндэсний компаниудын бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг шууд худалдан авах, бүтээгдэхүүний ашиглалт, хөгжүүлэлтийг гүйцэтгэгч компани тодорхой хугацаагаар хариуцах, худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон мэдээллийн системийг засах, сайжруулах, хөгжүүлэх ажил, үйлчилгээг нэг эх үүсвэрээс буюу мэдээллийн системийг гүйцэтгэгч этгээдээс худалдан авах зэрэг асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тусгаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсээд байна.

Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай” 127 дугаар тогтоолын 5-д “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хориглосугай.” гэсэн шийдвэрийг гарган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Асуулга 5: Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгч, улсын нэгдсэн төсвийн ангилалд мэдээллийн технологийн арга хэмжээ болон кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр бий болгож, тэдгээрийг программ хангамж, техник хангамжийн зардлаар ялган бүртгэх нөхцөлийг бүрдүүлэхийг даалгасан байхад өнөөдрийг хүртэл баталж, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан:

Иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, сүлжээнд чиглэсэн кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-т Кибер аюулгүй байдлыг хангах зардлын ангиллыг шинээр нэмж тусгахаар ажиллаж, зардлын эдийн засгийн ангилалд 2025 оны 3 дугаар улиралд 80317 код бүхий “Кибер аюулгүй байдлыг хангах” шинэ зориулалтыг бий болгож, 2026 онд 3.9 тэрбум төгрөгийн төсөв батлуулаад байна.

Түүнчлэн хувийн хэвшлийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын мэдээллийн систем, сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТУГ-ын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэж, 2023 оноос хойших хугацаанд нийт 14.4 тэрбум төгрөгийн төсөв төлөвлөсөн.

Мөн төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан цахим систем, программ хангамж, өгөгдлийн сан, платформын хөгжүүлэлтийн өртгийг бүртгэх зориулалттай "222003" код бүхий "Цахим систем" хөрөнгийн зардлын шинэ ангиллыг Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалаар батлаад байна.

Асуулга 6: Хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн программ хангамж хөгжүүлэлтээр хязгаарласныг "техник хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээ, их өгөгдөл, аналитик, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, аудит нийцэл" зэргээр салбарыг бүхэлд нь хамруулах талаар Засгийн газраас баримталж байгаа бодлого:

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "мэдээллийн технологи гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан тоон өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох үйл ажиллагааг;" гэж, 4.1.2- т "дэвшилтэт технологи гэж шинжлэх ухааны судалгаа, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх технологийг;" хэмээн тус тус тодорхойлсон.

Улмаар дэвшилтэт технологийн жагсаалтыг 2026 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. Уг жагсаалтад их өгөгдөл, хиймэл оюун, кибер аюулгүй байдлын чиглэлийн технологийг нарийвчлан тодорхойлох бөгөөд тэдгээртэй холбоотой технологийг дэмжих зохицуулалт тусгагдсан болно.